**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 02 өдөр Дугаар 01 Баянгол

Сумын 2017 оны төсвийн гүйцэтгэл
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1-ийн 2, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 1-ийн 3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сумын 2017 оны орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг 1420357,6 мянган төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 1392995,4 мянган төгрөгөөр тус тус батлсугай.

2. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэх, төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх, өр авлага бууруулах ажил зохион байгуулж, төсвийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын төсвийн ерөнхийлөн захирагч /М.Тунгалагтамир/-д үүрэг болгосугай.

3. Төсвийн тухай хууль болон бусад эрх зүйн актын хүрээнд төсвийг үр ашигтай, зохистой удирдах, түүнд тавих хяналт, сахилга хариуцлагыг дээшлүүлэн ажиллахыг төсвийн шууд азхирагч нарт даалгасугай.

ДАРГА Б.МАНДАХ

00701802